

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД  
БОДЛОГО 90-ЭЭД ОНД

Ц. Гомбосүрэн\*

XX зууны сүүлчийн арван жил-90-ээд оныг улс төр, нийгэм, философи сэтгэлгээ, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн зэрэг салбарт дэлхийг хамарсан их давалгааны он жилүүд болж байна гэлтэй. Тэгвэл энэ давалгааны хамгийн хүчтэй цохилт нь социалист гэгдэж байсан системийг голлон дайрснаар, хоёр зууны зааг дээр олон улсын харилцааны шинэ тогтолцоо бүрдэх үйл явц нэгэнт эхэлжээ. Хоёр системийн тэмцэл буюу “хүйтэн дайны үеийн харилцаа ард хоцорлоо. Дэлхийн улс гүрнүүд нэг талаас оршин тогтнох, хөгжих шаардлагын үүднээс ойртож, хамтын ажиллагаа харилцан хамаарал нь өргөсөж, олон улсын харилцаа бүхэлдээ ардчилагдах төлөвтэй байхад нөгөө талаас соёл, шашин, үндэсний онцлогоос үүдэлтэй зөрчил нэмэгдэж дэлхийн янз бүрийн бүс нутагт сөргөлдөөний байдал үргэлжилсээр байна.

Гүн гүнзгий өөрчлөлтийн хүчтэй давалгаа манай Монгол орныг ч тойрч гарсангүй. Бидний 70-аад жил оршин тогтнож ирсэн гадаад орчин нөхцөл үндсээрээ өөрчлөгдлөө. Дотооддоо мөн ялгаагүй, Монгол орны улс төр, нийгэм-эдийн засгийн байгуулал эрс өөрчлөгдлөө. Эдгээр ардчилсан өөрчлөлтийг Монгол Улс шинэ Үндсэн хуулиараа хуульчлан бататгасан билээ.

Монгол орны гадаад, дотоод байдлын энэхүү өөрчлөлттэй хамт тус улсын гадаад бодлого шинэчлэгдэж эхэлсэн билээ. Чухамдаа дээрх өөрчлөлтийн үр дүнд Монгол Улс харьцангуй бие даасан, үндэсний эрх ашгаа дээдэлсэн нээлттэй гадаад бодлого явуулах боломжтой болсон юм.

Манай улсын өөрчлөлт шинэчлэлтийн үеийн гадаад бодлогын мөн чанар өмнөхөөсөө юугаараа ялгаатай вэ?

Нэгдүгээрт: **Гадаад бодлогын онолын үндэс нь бүхэлдээ өөрчлөгдөв.** Урьд нь БНМАУ-ын гадаад бодлого “социалист маягийн шинэ харилцаа бүрэлдэх ёстой” гэсэн үзэл санаанд тулгуурлаж байсан бол өнөөдөр гадаад улс төр, эдийн засаг болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл онолд тулгуурлах боллоо. Гэхдээ бид онолын эдгээр номлолоос зөвхөн Монгол Улсын үндэсний эрх ашигт нийцэх тэр л үндэслэлүүдийг авч байгаа юм. Жишээ нь “Realpolitic” буюу улс төрийн реализмын онол, практикаас бид үндэсний эрх ашгийн тухай сургаалийг нь, улс төр, эдийн засгийн

\*Ц. Гомбосүрэн - Монгол Улсын Гадаад харилцааны сайд

онолоос эдийн засгийн тусгаар тогтнолоо хамгаалах сургаалийг нь, олон улсын эрх зүйгээс үндсэн хуульд харшлаагүй тэр хэсгийг нь тус тус авч, бүтээлчээр хандах чиг шугам баримталж байна. Энэ нь чухамдаа монголын гадаад бодлого прагматик шинжийг олсон хэрэг юм.

Хоёрдугаарт: **Манай гадаад бодлогын зорилго нь өөрчлөгдсөн юм.**

Урьд бид дэлхийн хувьсгал, социализмын тухай үзэл санааг дэлгэрүүлэх явдлыг гол зорилгоо гэж үзэж байсан бол өнөөдөр бид үндэсний эрх ашгаа хамгаалах явдлыг гол зорилгоо гэж үзэж, үйл ажиллагаагаа түүнд чиглүүлж байна. Үндэсний эрх ашиг гэдэг ойлголтыг бид хэтийн, ойрын гэж хоёр ангилж үзвэл хэтийн буюу байнгын эрх ашигт тус улсын үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдал, ард түмний хангалуун амьдралыг хангах явдал, Монгол Улсын хөгжил дэвшил, ойрын ашиг сонирхол гэдэгт зах зээлийн эдийн засагт шилжих гадаад таатай нөхцөлийг хангах, шинэ Монголыг дэмжигчдийн эгнээг өргөтгөх, бүс нутгийн интеграцид өөрийн гэсэн байр суурьтай болохыг оруулж ойлгож байна.

Гуравдугаарт: **Гадаад бодлогод баримталдаг зарчмууд.** Урьд нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрхийн зарчмуудаас гадна социализмын гадаад бодлого өөр зарчимд тулгуурладаг гэж ойлгон дэлхийн улс гүрнүүдийг гурав хувааж, бүлэг бүртэй нь өөр өөр зарчмаар харилцаж байлаа. Тэгвэл өнөөдөр бид дэлхийн аль ч улстай нээлттэй байж, НҮБ-ийн дүрмийн зарчим, хэм хэмжээнд тулгуурлан харилцаж байна. Үүний зэрэгцээ цэргийн аливаа эвсэл, бүлэглэлд үл нэгдэх, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй байх, гадаадын цэрэг, зэвсэг, түүний дотор цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ л байрлуулах зарчим баримталж байна.

Дөрөвдүгээрт: **Гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүд өөрчлөгдлөө.** Урьд бид үндсэндээ ганц тэргүүлэх чиглэлийн тухай ярьж байсан бол өнөөдөр 6 чиглэлийг тодорхойлж байна. Тэгэхдээ энэ бол зөвхөн тооны бус, бас чанарын өөрчлөлт гэдгийг хэлэх ёстой. Энэ талаар би эргэж ярих болно.

Тавдугаарт: **Гадаад бодлогын үр дүнгийн шалгуур шинэчлэгдлээ.** Гадаад бодлогын үр өгөөжийг юуны өмнө манай улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын эрх ашиг хэрхэн хангагдаж байгаа, зах зээлд шилжих, ард түмнийхээ амьдралыг дээшлүүлэхэд гадаад улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёл, хүмүүнлэгийн харилцаа хэр өгөөжтэй үйлчилж, гадаадын тусламж дэмжлэгийг хэр олж, тус улсын олон улсын байр суурь хэр бэхжиж, нэр хүнд нь яаж өсч байгаагаар тодорхойлж байна.

Эцэст нь гадаад бодлогын шийдвэр гаргадаг арга механизмыг өөр болголоо. Монгол Улсын шинэ Үндсэн хуулинд гадаад бодлогын үндсийг Улсын Их Хурал тодорхойлж байхаар заасан бөгөөд гадаад бодлогын асуудлаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын эрх, үүргийг тодорхойлов.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын зарим асуудлыг хөндөхийн өмнө өнөөдрийн Монгол Улс олон улсын харилцааны субъектын хувьд чухамдаа ямар ямар өгөгдөхүүнтэй улс болоод байна вэ? гэсэн асуултад эхлээд товч хариулахыг оролдоё.

Гадаад талаас нь авч үзвэл

Монгол Улс нь цэргийн хувьд хүчирхэг цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй, дэлхийн болоод бүс нутгийн зам, тээврийн сүлжээнд олигтой холбогдож чадаагүй, гадаад ертөнцтэй харилцахад хөрш хоёр гүрнээс бодит хамааралтай, олон улсын хамтын ажиллагаа, бүс нутгийн интеграцчилалд бага хамрагдсан хөгжиж байгаа орон юм. Гэхдээ ардчилал, шинэчлэлтийн замд орж, дэлхийн хамтын нийгэмлэгт зохих байр сууриа олж, өндөр хөгжилтэй ардчилсан орнуудын дэмжлэгийг авч байгаа орон.

Дотоод талаас нь авч үзвэл

Монгол Улс өргөн уудам газар нутагтай, тархай бутархай суурьшсан цөөн хүн амтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай, нүүдлийн мал аж ахуй, эрдсийн болон мал аж ахуйн түүхий эд боловсруулалтад голчлон суурилсан эдийн засагтай, дэд бүтэц сул хөгжсөн, санхүү, валютын нөөцөөр хомс, эдийн засгийн чадавхи багатай орон юм. Үүний зэрэгцээ улс төр, эдийн засгийн шинэ тогтолцоонд орох шилжилтийн үеийн хүнд бэрхшээлүүдийг туулж байгаа орон.

Гэхдээ нөгөө талаас өнөөгийн Монгол улс маань ардчиллын түгээмэл үнэт зүйлсийг удирдлага болгон өөрчлөлт шинэчлэлийн замаар иргэний шударга нийгэм байгуулахыг зорьж буй утгаараа түүний бүх нааштай потенциалыг өөртөө агуулж буй орон. Түүнчлэн байгалийн баялгийн их нөөцтэй, хүн амтай нь харьцуулахад мал сүрэг арвинтай, хүн ам нь харьцангуй боловсролтой, үндэсний хэмжээнд ард түмний эв нэгдэл төлөвшсөн орон. Монгол Улс олон улсын харилцааны субъектын хувьд иймэрхүү өгөгдөхүүнтэй гэж төсөөлөгдөж байна. Өөрөөр хэлбэл гадаад түншийн нүдээр харахад бидний давуу болон сул тал эндээс эхэлнэ.

Энэ бүхнийг иш үндэс болгон өөрийн орны бодит боломжийг харгалзан үзэж, тал талаас нь гүн хэлэлцээд Монгол

Улсын Их Хурлаар манай улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг саяхан батлан гаргалаа.

Өнөөдрийн бага хурлаар энэхүү үзэл баримтлалыг дэлгэрүүлэн ярилцаж гүнзгийрүүлэн ойлгох, хэрэгжүүлэх арга замыг товлоход санаа оноо хуримтлуулахыг бид зорьж байна.

Энэхүү үзэл баримтлал манай гадаад бодлогын өнгөрсөн дөрвөн жилийн туршлагаар нотлогдсон практикт суурилахын хамт орчин цагийн олон улсын харилцааны хөгжлийн чиг хандлагыг Монголын хөрсөнд тусгасан баримт бичиг бөгөөд энэ утгаараа 1990-ээд оны монголын гадаад бодлого, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр юм.

Гэхдээ энэ баримт бичиг бол огт хөдөлбөргүй зүйл биш. Түүнд шаардлагатай тухай бүр зохих нэмэлт өөрчлөлт оруулж нарийсган тодотгож, уян хатан хандаж байх ёстой гэж бодож байна.

Үзэл баримтлал бүтцийн хувьд улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, соёл хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлого гэсэн 4 үндсэн бүлэгтэй. Тэр бүгдийн талаар би задалж ярихгүй, гол анхаарлаа улс төрийн гадаад харилцааны асуудалд хандуулъя. Үг хэлэх хүмүүс бусад чиглэлээр нарийсгаж ярих байх.

Үзэл баримтлалд Монгол Улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх бодлого явуулна гэж заасан. Нээлттэй бодлого гэдэгт бид улс төрийн хувьд, эдийн засгийн хувьд, шинжлэх ухаан, технологийн хувьд, мэдээллийн хувьд, соёл, хүмүүнлэгийн хувьд гэхчилэн бүхий л салбарт нээлттэй байхыг хамруулж ойлгож байгаа юм. Гэхдээ аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ Эдийн засгийн, цагаачлалын, шашны гэх мэт/. Өөрөөр хэлбэл нээлттэй бодлого гэдэг маань тус улсын үндэсний ашиг сонирхолд хохирол учруулахгүй түүнд харшлахгүй тэр л хэмжээнд байх ёстой гэж бид ойлгож байгаа. Үндэсний эрх ашигт л хохирол учруулахгүй бол бид аль ч улстай үл сөргөлдөх, үл дайсагнах, найрсгаар хамтран ажиллах бодлого явуулах юм.

Эвсэлд үл нэгдэх бодлого өргөн хүрээтэй ойлголт бөгөөд бидний хувьд тэр утгаар нь авч үзэхийн сацуу хоёр хөршийнхөө аль нэгтэй цэрэг-улс төрийн холбоотны харилцаанд орж нөгөө хөршийнхөө эсрэг эвсэхгүй байх, эсвэл бусад улс гүрэнтэй тийм холбоонд орж, хоёр хөршийнхөө эсрэг үйл ажиллагаа явуулахгүй байхыг юуны өмнө ойлгож байгаа юм.

Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхлыг улс төр дипломатын аргаар хангах нөхцөл бүрэлдүүлэх явдал тус улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн гэж үзэл баримтлалд тодорхойлсон. Ийм таатай нөхцөлийг улс төр, эрх зүй, эдийн засаг,

мэдээлэл, сэтгэл зүй, сурталчилгааны зэрэг чиглэлээр бүрдүүлэх ёстой гэж бид ойлгож байна.

Сүүлийн 4-5 жилийн хугацаанд бид улс төрийн гадаад таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлд нэлээд урагшилсан гэж хэлж болно.

Чухамдаа дээрх зорилтын хүрээнд Монголын төр, засгийн тэргүүн нарын ОХУ, БНХАУ, АНУ, Япон, ХБНГУ, Франц, БНСУ, Энэтхэг, Тайланд, Лаос, Вьетнамд, Япон Улсын Ерөнхий сайд, БНХАУ-ын дарга, мөн Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд, Украин, Казахстан, Киргиз улсын Ерөнхийлөгч, Беларусийн Ерөнхий сайд, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга, Авсралийн Амбан захирагч нарын Монголд хийсэн айлчлалыг хэрэгжүүлсэн юм. Үүний зэрэгцээ Парламент, Засгийн газрын шугамаар хоёр талын өндөр хэмжээний уулзалт яриаг олон улс оронтой хэрэгжүүллээ.

Өнөөдөр Монгол Улс хоёр хөрштэйгөө шинэ маягийн найрсаг харилцааг төлөвшүүлэн тогтоож байгаа бөгөөд Өрнө , Дорнын өндөр хөгжилтэй нэр бүхий 20 гаруй улс тус улсын өөрчлөлт шинэчлэлийг улс төр, ёс суртахууны хувьд төдийгүй эдийн засаг, санхүүгийн хувьд бодитой дэмжиж байна.

Цаашид эдгээр ололтыг бататгаж, үр нөлөөг дээшлүүлж, харилцааны материаллаг үндсийг бэхжүүлэхэд бидний үйл ажиллагааны үзүүр чиглэх ёстой гэж бодож байна.

Гадаад харилцааны эрх зүйн таатай нөхцөл бүрэлдүүлэх ажлыг хоёр чиглэлээр хийх ёстой юм. Нэгдүгээрт, хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг холбогдох гэрээ хэлэлцээр байгуулах буюу олон талт - гэрээ хэлэлцээрт нэгдэх замаар бүрэлдүүлэх, хоёрдугаарт, гадаад харилцаанд холбогдох буюу зохицуулах дотоодын хууль тогтоомжийн тогтолцоог бүрэлдүүлэх шаардлагатай.

Хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай шинэ харилцааныхаа эрх зүйн үндсийг бүрэлдүүлэх ажлын эхний шатыг үндсэнд нь дуусч байна, Хуучин ЗХУ-тай цэрэг, улс төрийн холбоо тогтоож байсан Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах тухай 1966 оны Гэрээг орчин үеийн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн шинэчлэн байгуулав. Ингэснээр Монгол, Оросын.. харилцааг олон жилийн турш ноёрхож байсан үзэл суртлын хүлээсээс гаргаж, жинхэнэ тусгаар тогтнож, бие даасан улсуудын хэмжээнд эрх тэгш өжхарилцах эрх зүйн үндсийг тавилаа.

БНХАУ-тай 1960 онд байгуулсан Найрамдал, харилцан туслах тухай Гэрээг 1994 онд шинэчилж, найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ байгуулав. Уг гэрээнд тус хоёр улс бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн

бүтэн байдлыг харилцан хүндэтгэх зарчмын үндсэн дээр харилцаагаа хөгжүүлэхээр заасан нь Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчныг бүрдүүлэхэд түүхэн ач холбогдолтой зүйл болсон юм.

Хуучин социалист гэгдэж байсан орнуудтай гэрээ хэлэлцрийг шинэчлэх ажил хийгдэж байна. Тэгш бус буюу манай Шинэ Үндсэн хуульд харшлах бүх гэрээ хэлэлцээрийг хүчингүй болгосон.

Украйн, Казахстан, Киргизстан, Энэтхэг улсуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ шинээр байгуулав.

Эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах, давхар татвараас чөлөөлөх тухай зэрэг худалдаа-эдийн засгийн харилцааны эрх зүйн ерөнхий хүрээг тогтоодог баримт бичгүүдийг одоогоор 20 гаруй оронтой байгуулсан буюу байгуулахаар тохиролцоод байна.

Дотоодын нэлээд хууль гарлаа: Гадаадын хөрөнгө оруулалтын, Гаалийн татварын гэх мэт.

Нөгөөтэйгүүр дотоодынхоо хуулиудыг олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээтэй нийцүүлэхийг зорих ёстой.

Эдийн засгийн таатай нөхцөл бүрдүүлэх гэдэгт бид юуны өмнө гадаад орон, түншүүдтэй хамтран ажиллах, тухайлбал хөрөнгө оруулахад дотоодын хөнгөлөлтийн систем бий болгох, үйлдвэрлэлийн болон зах зээлийн эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлж боловсронгуй болох банк, санхүү, гааль, татварын алба гэх мэт/, газар эзэмших, ашигт малтмал олборлох, боловсруулахтай холбогдсон харилцааг оновчтой зохицуулах, концесси Олгох, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зэрэг олон асуудлыг шийдвэрлэх санааг ойлгож байгаа юм. Цаашилбал нэгэнт сонгосон бодлогоо тууштай явуулах, найдвартай түнш гэдгээ үйл ажиллагаа, хууль тогтоомжоороо нотолж байх санааг ойлгож байгаа юм.

Мэдээлэл, сэтгэл зүй, сурталчилгааны таатай нөхцөл бүрдүүлэх тухайд гэвэл манай түншүүдийн тухай дотооддоо бодитой мэдээлэл түгээх, улс орныхоо тухай гадаадад өргөн мэдээлэх, буруу зөрүү мэдээг залруулах, Монголын талаар сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, Монголыг дэмжигчдийн эгнээг өргөтгөх, лобби бий болгох зэргийг хамааруулж ойлгож байна.

Эдгээр нөхцөлийг бүрдүүлэхэд Монголын хууль тогтоох байгууллага, Засгийн газар, Хэвлэл мэдээллийн байгууллагууд хүч чармайлтаа нэгтгэн ажиллах учиртай юм.

Үзэл баримтлалд Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх зорилтыг 6 чиглэлд ангилж тодорхойллоо. Эн тэргүүний зорилт бол Хөрш хоёр оронтой найрсаг харилцаа, тал бүрийн хамтын ажиллагаа хөгжүүлэх явдал юм. Чингэхдээ аль нэгийг өрөөсгөл дагахгүй, Хоёулантай нь тэнцвэртэй харилцах зарчмыг баримтлах бөгөөд харилцааны уламжлал, онцлогийг бодитойгоор харгалзаж байхаар заасан.

Монгол улсын гадаад бодлогын хоёр дахь чиглэл бол Өрнө, Дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх зорилт юм. Энэ зорилтын хүрээнд АНУ, Япон, Европын холбоотой харилцаа хөгжүүлэхийг чухалчилан анхаарахын хамт Ази, Европ, Америк тивийн уламжлалт харилцаатай болон шинэ түнш улсуудтай идэвхтэй хамтран ажиллах бодлого баримтална.

Манай гадаад бодлогын гурав дахь чиглэл нь Азийн бүс нутагт байр сууриа бататгаж, эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал юм.

Энэ зорилтын хүрээнд Ази, Номхон далайн чиглэл, цаашилбал Зүүн хойд Ази, Төв Азийн чиглэлд түлхүү анхаарах юм. Бүсийн байгууллагууд дотроос АПЕК-т гишүүнээр элсэн орох зорилтыг үзэл баримтлалд тусгасан. Энэ байгууллагад гишүүнээр элсэх, түүний Гишүүн орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хэрэгжүүлэх замаар бүс нутгийн интеграцид илүү оновчтой оролцох нөхцөл бүрдэх юм.

Гадаад бодлогын дөрөв дэх чиглэл нь НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтран ажиллах явдал байх юм.

Цаашилбал социалист хамтын нөхөрлөлийн Гэгдэж байсан орон нууд, ТТУХН-ийн улсуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх нь манай гадаад бодлогын тав дахь чиглэл байх юм. Эдгээр улстай харилцахдаа Өмнөх харилцааны нааштай өвийг бататгахын хамт харилцаагаа шинэ нөхцөл байдалд зохицуулан, бодит боломжийг харгалзан, учир ялгавартай хандана.

Эцэст нь хөгжиж байгаа орнуудтай найрсаг харилцаатай байж, нийтлэг зорилгоо шийдвэрлэх үүднээс бодит боломжийн хэмжээнд тэдгээртэй хамтран ажиллах явдал гадаад бодлогын зургаа дахь чиглэл байна. Энэ зорилтыг хоёр талын харилцааны хүрээнээс гадна голчлон Олон улсын байгууллага, хөдөлгөөний хүрээнд, тухайлбал НҮБ, "77". гийн бүлэг, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэгт хамтран ажиллаж, замаар хэрэгжүүлнэ.

Үзэл баримтлалд Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхий дахины чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйлсэд боломжийн хэрээр идэвхтэй хувь нэмэр оруулахыг чармайна гэж заасан. Олон улсын харилцааг ардчилах, НҮБ-ын үүрэг ролийг дээшлүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийг устгах, түүнчлэн нийгэм, эдийн засаг хөгжлийн өдий төдий асуудал шийдвэрээ хүлээж байгаа билээ. Энэ чиглэлд бидний дангаараа хийх зүйл бага. Гэхдээ эрх ашиг нэгтэй улс орнуудтай байр сууриа зохицуулах замаар, олон улсын харилцааны өнөөгийн хөшүүргүүдийг оновчтой ашиглах замаар, тэдгээрийг боловсронгуй болгох замаар бид нийтийн үйлсэд хувь нэмрээ оруулж чадах ёстой.

Гадаад бодлогын үзэл баримтлалын улс төрийн бодлогын хэсэгт туссан зарчмын чанартай зүйлээр хийх товч тайлбарыг үүгээр хязгаарлая.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг тодорхой хэрэгжүүлэх явдал гадаад харилцаанд оролцогч байгууллагууд, түүний Дотор ГХЯ, системийн байгууллагуудын хүч чармайлт, анхаарлыг байнга төвлөрүүлэх зорилт болж байна.

Үүнтэй холбогдуулж зарим нэг санаа хэлье.

1. Хоёр хөрштэйгөө тогтоосон харилцааг тогтвортой удаан хугацаанд хөгжүүлэх алс ирээдүйгээ харсан цэгцтэй бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй болж байна.

2. Монгол, Орос, Хятадын гурвалжингийн хүрээнд тодорхой асуудлаар зөвлөлдөх, харилцан зохицуулалт хийх механизмтай болох шаардлага ч байж болох юм. Манай гурван улс хил залгаа оршдогийн хувьд улс төр, эдийн засаг, гааль, зам тээвэр, харилцаа холбоо, аж ахуй, байгаль орчны зэрэг хамтран шийдвэрлүүштэй нийтлэг асуудал олон бий билээ. Хөрш хоёр оронд олон сая монгол туургатнууд оршин суудаг, тэдгээртэй хэл, соёл, зан заншлын уламжлалаа харилцан баяжуулах шаардлага байгааг бодож үзвэл мөн “Нармай Монголын тухай үзэл”-ийг тойрсон элдэв хардлага байн байн цухалздагийг бодолцвол гурван талын хамтын ажиллагаа хэрэгтэй байхаар төсөөлөгдөж байна.

3. Өрнө, дорнын өндөр хөгжилтэй улс гүрнүүдтэй харилцах харилцаанд, ялангуяа эдийн засгийн харилцаагаа хөгжүүлэх, тэдний эдийн засгийн сонирхлыг Монголд бий болгох, гадаадын хөрөнгө оруулах, найдвартай түнш нь болох чиглэлд идэвхтэй хүч чармайлт тавих хэрэгтэй болж байна.

4. Монгол Улс Ази, Номхон далайн эдийн засгийн интеграцчиллын үйл явцад оролцох чиглэлд илүү анхаарах ёстой. Тус бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны нөлөө бүхий байгууллага болох АПЕК-тай хамтран ажиллах, улмаар түүнд гишүүнээр элсэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулбал зохино. АПЕК-ийн гишүүн орнуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, манай гадаад эдийн засгийн харилцаанд тэдний эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх, тэдний дэмжлэгийг олж авахын төлөө идэвх чармайлт гаргах нь зүйтэй гэж үзэж байна. Түүнчлэн АПЕК-ийн ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд оролцох явдал АПЕК-т элсэх бэлтгэлийг хангах, гишүүн орнуудтай ойртон хамтран ажиллах нэг гол хэлбэр болох ёстой.

5. Зүүн хойд Азийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үзэл санааг идэвхтэй дэмжиж ажиллах ёстой гэж үзэж байна

6. Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн бүс нутгийн улс орнуудын чармайлтад бололцооны хэрээр дөхөм үзүүлэх, энэ талаар хоёр болон олон талт яриа хэлцээ өрнүүлэхэд идэвхтэй оролцох нь 1990-ээд оны Монгол улсын гадаад бодлогын чухал зорилт болно.

1. Олон улсын байгууллагуудын хүрээнд хуримталсан санхүү, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, технологи, оюуны их чадавхийг улс орны хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд чадварлагаар ашиглахыг эрмэлзэх хэрэгтэй байна.

8. Шинжлэх ухаан, технологи, соёл хүмүүнлэгийн гадаад харилцаа нь улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил, монгол туургатны соёл иргэншлийг хамгаалах, боловсронгуй болгож хөгжүүлэх, үндэсний боловсон хүчнийг бэлтгэхэд үндсэндээ чиглэгдэх ёстой. Энд бүхий л талын боломжийг цаашид ч хайж, ажиллах шаардлагатай байна.

9. Цаашилбал бид мэдээлэл, судалгааны ажлын түвшинг эрс дээшлүүлэх талаар анхаарах ёстой. Бид мэдээлэл, судалгаагаа сайжруулахгүйгээр гадаад бодлогын үр өгөөжийг дээшлүүлэх тухай ярихын ч хэрэггүй.

Өөрөөр хэлбэл гадаад харилцааны үйл ажиллагаа, шинжлэх ухааны холбоог эрс сайжруулах шаардлага улам хурц тавигдаж байна.

10. Монгол Улсын иргэдийн эрх ашгийг гадаадад хамгаалах, консулын ажил үйлчилгээг идэвхжүүлэх талаар мэдэгдэхүйц өөрчлөлт хийх ёстой байна.

11. Гадаад харилцаанд оролцогч манай байгууллагуудын ажлын уялдаа холбоо, зохицуулалт, харилцан мэдээлэл солилцох явдлыг эрс сайжруулах, ялангуяа ГХЯ-ны гадаад бодлогын нэгдлийг хангах үүргээ биелүүлэх боломжийг бүрдүүлэх тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзнэ.

12. Гадаад бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хувь заяа эцсийн эцэст боловсон хүчний бэлтгэл, боловсрол мэдлэг, хариуцлагаас хамаарна. Үүнтэй уялдан үндэсний дипломат албыг бэхжүүлэх, ажиллагсдын ахуй нөхцөлийг сайжруулах, боловсон хүчин бэлтгэх тогтолцоог бий болгох, Дипломат албаны хуулийг даруй боловсруулж гаргах зэрэг ажлыг хийх зорилт тулгарч байна.

Гадаад бодлогын шинэ зорилтуудыг хэрэгжүүлэхэд объектив болон субъектив шинжтэй бэрхшээлүүд тохиолдох нь ойлгомжтой. Гаднаас шалтгаалах ч зүйл бий, биднээс шалтгаалах зүйл ч, урьдаас өвлөгдсөн бэрхшээлтэй асуудлууд ч байна, шинээр гарч ирж байгаа цаг үеийн дуудлага ч байна. Санхүүгийн хомсдол ч тодорхой хэмжээний сааруулагч хүчин зүйл болж байна.

Гадаад бодлого Монгол Улсын оршин тогтнох болон хөгжин дэвшихийн нэгэн язгуур хүчин зүйл байсан, цаашид ч байх болно. Энэ утгаараа түүнийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж оновчтой явуулах нөхцөлийг бүх талаар бүрдүүлэх явдал төр, засгийн онцгой анхаарлын объект цаашид ч байна гэдэгт бид эргэлзэхгүй байна.

**АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД  
НӨХЦӨЛ, МОНГОЛ УЛСЫН БОДЛОГО  
\*Ж. Энхсайхан**

“Хүйтэн дайн дуусч, хоёр туйлт ертөнц үгүй болсон билээ. Зүүн Европ, Евразийн ууган нутгийн улс түмэн улс төрийнхөө тусгаар тогтнолыг сэргээх буюу зарлаж, улс орноо ардчилал, зах зээлийн эдийн засгийн замаар хөгжүүлэх бодлого явуулж байна. Хэдийгээр дэлхий дахины, түүний дотор цөмийн дайны аюул багасч, улс